Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
195 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- [√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- [ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыгбаталсан огноо:

| | |
|---|---|
| **Байгууллагын нэр:** | **Нэгжийн нэр:** |
| Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар | |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** |
| Газар, газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны үнэлгээ-аудит, хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-5 |
| **Ажлын цаг:** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдөр 8 цаг | Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, газар, газрын хэвлий, түүний баялаг, тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын өмнө хариуцна.

| Албан тушаалын зорилт: <br>1. Газар, газрын хэвлий түүний баялгийг хамгаалах зүй зохистой ашиглах, уул уурхайн нөхөн сэргээлтийн талаар гарсан хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг ханган аймгийн Засаг даргаас дэвшүүлсэн бодлого, хөтөлбөр, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах.<br>2. Газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах.<br>3. Тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалт, хамгаалалт, менежментийн хэрэгжилтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.<br>4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | | | |
|---|---|---|---|
| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Газрын хэвлий, ашигт малтмалын талаар батлагдсан хууль тогтоомжид заасан арга хэмжээг хэрэгжүүлэх; | Хууль тогтоомжийн хэрэгжилтээр, | Г, Х |
| | 2. Ашигт малтмалыг зүй зохистой ашиглуулах, олборлолтын явцад хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийлгүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, хяналт тавих; | Нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэсэн байна. | Г, Х |
| | 3. Газрын төлөв байдал, чанарын болон газар, газрын хэвлийн холбоотой эрхийн бүртгэлийн мониторингийг орон нутагт хэрэгжүүлэх; | Газрын төлөв байдал, чанарын баталгаа, эрхийн бүртгэл хугацаандаа хийгдсэн байна. | Г, Х |
| | 4. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээнд тавих байгаль орчны хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах; | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтээр, | Х |
| | 5. Сум, орон нутагт газар, түүний хэвлийг нөхөн сэргээх бодлого чиглэл боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэшил, арга зүйгээр хангах. | Мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. | Г, Х |
| | 6. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, | Хэрэгжилтийн тоогоор, | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | батлуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах. | | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төслүүдийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамруулах, байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах;<br>2. Харьялах төслүүдэд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хянаж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, | Байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна. | Г<br>Г, Х |
| | 3. Байгалийн нөөц ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны аудит хийлгэх ажлыг орон нутагт зохион байгуулах, аудитаар тогтоосон дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангуулахад хяналт тавих. | Байгалийн нөөц ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд аудит хийлгэж, илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. | Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг тухайн хамгаалалтын захиргаатай хамтран боловсруулж батлуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллах, хамгаалалтын захиргаатай үйл ажиллагаагаа уялдуулах; | Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байх. | Г, Х |
| | 2. Улсын тусгай хамгаалалттай газрын болон усны Сав газрын захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хянаж хэрэгжилтийг хангуулах; | Тусгай хамгаалалтад авсан газар нутаг ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын хэлтсийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна. | Х |
| | 3. Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран | Тогтоол шийдвэрийн хэрэгжилтээр, | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | зохион байгуулах; | | |
| | 4. Газар зохион байгуулалтын аймаг, сумын жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; | Газар зохион байгуулалтыг ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж ажилласан байна. | |
| | 5. Газар зүйн мэдээллийн системийн асуудлыг хариуцах | Газар зүйн мэдээлэлд суурилсан мэдээллийн сантай болсон байна. | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1. Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах; | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. | Г |
| | 2. Газрын чиг үүргийн хүрээнд тайлагнах тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах; | Хэрэгжилт, үр дүнгээр, | Г |
| | 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, тайлагнах; | Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | Г |
| | 4. Хариуцсан ажлын чиглэлээр ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх; | Ирсэн бичиг, өргөдөл, гомдол шийдвэрлүүлсэн байдлаар, | Г |
| | 5. Компьютерын файлын эмх цэгцийг сайжруулах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг эмхлэн цэгцлэж, бүрэн бүрдэлтэй нь байгууллагын архивт хүлээлгэн өгөх; | Байгууллагын архивт хүлээлгэн өгсөн баримтын тоогоор, | Г |
| | 6. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг газрын даргын өмнө хариуцан ажиллах | Үүрэг даалгаврын биелэлтээр, | Г |
| | 7. Байгууллагын дотоод сүлжээг хариуцах | Мэдээллийн технологийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангасан байна. | Г |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | |
|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |

| | | |
|---|---|---|
| Мэргэжил | Уул уурхай, олборлолт /0724/, геологи /053203/, уул уурхайн ашиглалтын технологи /540300/, уул уурхайн эдэлбэр газрын кадастр /621500/. | |
| Мэргэшил | Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;<br>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх;<br>- нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;<br>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;<br>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;<br>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;<br>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;<br>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;<br>- бүтээлч, санаачилгатай ажиллах;<br>- бусад. |
| | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;<br>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;<br>- нээлттэй, шударга байх;<br>- бусад. |
| | Бусад | - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх,<br>- зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;<br>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;<br>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын |

| | | |
|---|---|---|
| | | чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх. |

| | |
|---|---|
| **IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ** | |
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:<br>Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга | |
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>- Байхгүй. | Бусад харилцах субъект:<br>- Салбарын яам, агентлагийн холбогдох мэргэжилтэн,<br>- Аймгийн ИТХ-ын ажлын алба,<br>- Аймгийн Засаг даргын орлогч,<br>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд,<br>- Салбарын байгууллагууд,<br>- Уул уурхай, нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөл бүхий ААНэгж, компаниуд<br>- Иргэн, хуулийн этгээд. |
| **V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ** | |
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br>БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН<br>Э.ЗОЛЗАЯА<br>20.19. оны .10. дугаар сарын .30.-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо:.....19 10 30<br>Дугаар:.........195 |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| Байгууллагын нэр:<br>ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: ................<br>Дугаар: ...............<br>(тамга/тэмдэг)<br>ДАРГА Т.АРИУНБОЛД<br>20... оны ... дугаар сарын ... -ны өдөр | |